



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 2.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод шинээр байгуулагдах 150 ортой Хүүхдийн төв эмнэлгийн хүний нөөцийг бүрдүүлэхээр 2015 онд зохион байгуулсан “Хүүхэд судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалт, “Нярай судлал”, “Хүүхдийн сэхээн амьдруулах/эрчимт эмчилгээ судлал”-ын төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаж, сургалтын хөтөлбөрөө дүүргэсэн эмнэлгийн мэргэжилтнээс шалгалт авах улсын шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Шалгалтыг журмын дагуу хараат бус, ил тод зохион байгуулж, тайланг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлд 2015 оны 12 дугаар сарын 20-ны дотор нэгтгэн хүргүүлж, тайлагнахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081183

Эрүүл мэнд спортын сайдын
2015 оны 07 сарын 07 өдрийн
336 дугаар тушаалын хавсралт



“Хүүхэд судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалт, “Нярай судлал”,
“Хүүхдийн сэхээн амьдруулах/эрчимт эмчилгээ судлал”-ын төрөлжсөн
Мэргэшлийн сургалтад хамрагдаж, сургалтын хөтөлбөрөө дүүргэсэн
Эмнэлгийн мэргэжилтнээс шалгалт авах улсын шалгалтын
комиссын бүрэлдэхүүн

№	Мэргэжлийн чиглэл	Комиссын бүрэлдэхүүн	Овог нэр	Албан тушаал, эрдмийн зэрэг, цол
1.	<u>Үндсэн мэргэжил</u> - Хүүхэд судлал <u>Төрөлжсөн мэргэшил</u> - Нярай судлал - Хүүхдийн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ судлал	Дарга	Ш.Энхтөр	Эрүүл мэнд, спортын яамны Хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, ЭХЭМҮТ-ийн захирал, анагаах ухааны доктор
2.		Нарийн бичгийн дарга	Д.Байгалмаа	Эрүүл мэнд, спортын яамны Хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, ЭХЭМҮТ-ийн Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын эмч, анагаах ухааны доктор
3.		Гишүүд	Г.Эрдэнэтуяа	Эрүүл мэнд, спортын яамны Хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, дэд профессор
4.			Д.Даваасүрэн	Эрүүл мэнд, спортын яамны Хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, дэд профессор
5.			А.Оюунчимэг	Эрүүл мэнд, спортын яамны Хүүхдийн

			мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, ЭХЭМҮТ-ийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга, хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч, клиникийн профессор
6.		Ц.Алтантуяа	Эрүүл мэнд, спортын яамны Хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, ЭХЭМҮТ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал, клиникийн профессор
7.		Ч.Наранцэцэг	ЭХЭМҮТ-ийн Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч, анагаах ухааны магистр